2018 оны 04 сарын 06-ны өдөр Дугаар А/305 Улаанбаатар хот

Нийслэлийн төр, захиргааны
байгууллагуудын ажлын цагийн
хуваарьт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “ж”, “к”, 29.2, Засгийн газрын 2014 оны 393 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах зорилгоор энэ захирамжийн хавсралтад заасан нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажил эхлэх цагийг 08 цаг 00 минут байхаар тогтоосугай.

2.Энэ захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд дагаж мөрдсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн
А/305 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬТ НЬ ЗОХИЦУУЛАЛТ
ХИЙХ НИЙСЛЭЛИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

| д/д | Байгууллага |
|---|---|
| 1 | Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба |
| 2 | Нийслэл, дүүрэг /Хороо/-ийн Засаг даргын Тамгын газар |
| 3 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, харьяа газар |
| 4 | Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг |
| 5 | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |